



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/191

Мандалговь

Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөнөөс
орон нутгийн төсөвт төвлөрсөн мөнгийг
зарцуулах тухай

Монгол Улсын “Цэргийн албаны тухай хууль”-ийн 31 дүгээр зүйлийн 8, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолын хавсралт “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 07 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс орон нутгийн төсөвт төвлөрсөн хөрөнгийг хавсралтын дагуу зарцуулахыг аймгийн Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д үүрэг болгосугай.

2. Шаардагдах 3.100.000 (гурван сая нэг зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



4822100471

Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын
26-ны өдрийн 19 дугаар захирамжийн хавсралт



2021 ОНД ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ МӨНГӨНӨӨС ОРОН НУТГИЙН
ТӨСӨВТ ТӨВЛӨРСӨН МӨНГИЙГ 2022 ОНД ЗАРЦУУЛАХ ТООЦОО

| д/д | Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоол /мөнгөн төлбөрийг зарцуулах журам/ | Хэрэгжүүлэх ажил | Тооцоо | Төсөв |
|----------------|--|--|---|--------------------|
| 1 | 4.1.9 Батлан хамгаалах үйл ажиллагааг, орон нутагт хэрэгжүүлэхэд идэвхи санаачлагатай ажилласан иргэн, албан тушаалтныг урамшуулах | Орон нутагт хэрэгжүүлэх ажилд идэвхи санаачлагатай ажилласан иргэнийг урамшуулах, хэрэгцээг хангах | Цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа иргэдийг шаардлагатай үед зарлан дуудаж бүтээн байгуулалт, бусад ажил хийхэд хоолны зардал | 3.100.000 мянга |
| Нийт 3.100.000 | | | | |

ЦЭРГИЙН ШТАБ